

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БАРИЛГА

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|
| Төслийн нэр | Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлгийн барилга |
| Байршил | Ховд аймаг Булган сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015-2016 |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Алслагдсан баруун сумдын иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлж улмаар хөрш зэргэлдээ ӨМОЗО-ны орны эмнэлгүүдтэй хоршин хөгжиж, иргэддээ орчин цагийн чанартай хүртээмжтэй үйлчилгээг хүргэнэ. |
| Төслийн явц | <ul style="list-style-type: none"> - Аймгийн 2012-2016 оны Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан - Шинэ барилга баригдах газрыг шийдвэрлэсэн. - Барилгын зураг төсвийг мэргэжлийн өндөр түвшинд хийлгэсэн - Техникийн нөхцлүүдийг бүрэн гаргуулсан - Ажлын зураг хийгдсэн - Экспертизээр баталгаажсан - 2015-2016 онд баригдахаар ажлын төлөвлөгөөнд тусгагдсан |
| Хамрах хүрээ | Аймгийн төвөөс алслагдсан, өвлийн улиралд зам хаагдаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүрэх боломж хомсддог Булган, Алтай, Үенч сумдын 20-иод мянган хүн амд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна хилийн боомтоор зөрчих / сард дунджаар 2-3 мянга орчим / иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалт, Концессийн болон Эрүүл мэнд бусад хууль тогтоомжоор зохицуулагдана |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар болон дэд бүтэц, түгээмэл тархацтай ашигт малтмал зэргийг олгоход хөнгөлөлт үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 1 тэрбум 200 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 1 тэрбум 200 сая |
| Үйлчилгээний хүчин чадал | Эмчлэн эрүүлжүүлэх, лаборатори оношлогоо, эмийн бус тасагтай, аж ахуй, удирдлагын болон туслах үйлчилгээний хэсгүүдээс бүрдсэн орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн 50 ортой тохилог эмнэлэг баригдах болно. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | <ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчдийн тоо, хүртээмж нэмэгдэж сэтгэл ханамж дээшлэнэ. • Үйлчилгээний чанар, орчин нөхцөл сайжирна. • Эмч мэргэжилтний мэргэжлийн түвшин эрс дээшлэнэ. • Нотолгоонд тулгуурласан оношлогоо эмчилгээ нэмэгдэнэ. • Техник технологийн дэвшилтэт үйлчилгээний төрлүүд нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн мэдээлэл авах хүртээмж сайжирна • Эрүүл мэндийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажлууд туурвих нөхцөл дээшлэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**30 ОРТОЙ ХАЛДВАРТЫН ЭМНЭЛЭГ БАРИХ ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | 30 ортой халдвартын эмнэлэг шинээр барих |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Сүүлийн жилүүдэд халдварт өвчин болох сүрьеэ, харшил, сэтгэц, халдварт шар өвчин болон малаас хүнд халдварлах халдварт өвчин ихэсч байгаа нь халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах цогц арга хэмжээ авах шаардлага тулгарч байна. Ховд аймгийн босоо тэнхлэгийн зам ашиглалтанд орсноор хөрш 2 орноос зорчих хөдөлгөөнт хүн амын тоо нэмэгдэж байгаа нь халдварт өвчин богино хугацаанд тархах нөхцлийг нэмэгдүүлж байна. |
| Төслийн явц | Халдвартын барилгын зураг төсөл бэлэн болсон, ТЭЗҮ гарсан |
| Хамрах хүрээ | Монгол орны нутаг дэвсгэрийн 27 хувь буюу 415.3 мян км кв нутагтай, нийт хүн амын 15.6 хувь нь оршин суудаг баруун бүсийн ард иргэдийг хамран үйл ажиллагаа явуулна. |
| Хууль эрх зүйн орчин | Шинэчлэлийн Засгийн газар болон Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хэмжээнд зайлшгүй шийдвэрлэхээр зорилтод тусгагдсан, Эрүүл мэндийн салбарт Засгийн газраас дэвшүүлж буй бусад төсөл хөтөлбөртэй уялдаж байгаа. Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар болон дэд бүтэц, түгээмэл тархацтай ашигт малтмал зэргийг олгоход хөнгөлөлт үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, хандив, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллага, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 500 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 500 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Нэгэн зэрэг 30 хүнд үйлчлэх хүчин чадалтай, төрөлжсөн тасгуудтай, тусгаарлах хэсгүүдтэй, орчин үеийн стандартад нийцсэн байна |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Халдварт өвчний талаар иргэдэд үйлчлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж чанар дээшлэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

ЗӨӨВРИЙН ФЛЮРГРАФИЙН АППАРАТЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|---|--|
| Төслийн нэр | Зөөврийн Флюрографийн аппарат |
| Байршил | Ховд дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төв |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс амьсгалын замын эмгэг тэргүүлэх болж, сүрьеэгийн халдвар нэмэгдэх хандлагатай байна. Тархай байршилтай, алслагдсан, зам бартаа ихтэй Ховд аймгийн хувьд иргэд эрүүл мэндийн үзлэгт төдийлөн хамрагдахгүйгээс өвчнөө хүндрүүлж эмнэлэгт хандах нь их байгаа ба зөвхөн уушигны зураг авахуулах, цээжний зураг авахуулахаар аймгийн төвд ирж байгаа нь цаг хугацааны хувьд өндөр эрсдлийг агуулж байна. Эрүүл мэндийн салбарын тэргүүлэх зорилт болсон өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд иргэдийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг өргөжүүлж нотолгоонд тулгуурласан оношлогоог өргөжүүлэхэд зөөврийн флюор аппарат зайлшгүй шаардлагатай юм. |
| Төслийн явц | Нийлүүлэгдэх аппаратны марк үнийг судалж тооцоолсон. |
| Хамрах хүрээ | Монгол орны нутаг дэвсгэрийн 27 хувь буюу 415.3 мян км ² нутагтай, нийт хүн амын 15.6 хувь нь оршин суудаг баруун бүсийн ард иргэдийг хамран үйл ажиллагаа явуулна. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалт, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Тээвэрлэлтийн зардлыг орон нутгаас шийднэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс болон хандив тусламжаар |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 195 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 195 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Жилд 130 000 гаруй хүнд оношлогоо хийх боломж бүрдэнэ. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Хөдөө болон багт оршин сууж буй ард иргэдэд газар дээр нь очиж оношлогоо хийснээр зардал багасч, хөнгөн шуурхай үйлчилж, эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээс гадна сүрьеэ өвчнийг эрт илрүүлэн оношлох, өвчлөлийг бууруулах ач холбогдолтой. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**СОРОНЗОН ДАВТАМЖИТ КОМПЬЮТЕРИЙН ТОМОГРАФИЙН
АППАРАТЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | Соронзон давтамжит компьютерийн томографи |
| Байршил | Ховд дахь БОЭТ |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2017 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Зөвхөн Ховд аймгаас жилд дунджаар 1400 гаруй иргэн Улаанбаатар хотод MRI оношилгоо хийлгэхээр явдаг тооцоо судалгаа гардаг. Үүнээс үзэхэд нэг хүн дунджаар 800 000-1 000 000 сая төгрөг зарцуулдаг. Энэ нь тухайн хүний хувьд цаг хугацааны хувьд цаг алдах мөн эдийн засгийн дарамт учирдаг. Эрүүл мэндийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж аппаратуудыг оношлогоо, эмчилгээнд шинээр нэвтрүүлэн ажиллаж байгаа өнөө цаг үед Баруун бүс нутгийн 1400 гаруй ард иргэд Соронзон давтамжит компьютерийн томограф (MRI)-ийн аппаратаар шинжилгээ хийлгэх эрэлт хэрэгцээ туйлын их байна. |
| Төслийн явц | Нийлүүлэгдэх аппаратны марк үнийг судалсан. |
| Хамрах хүрээ | Баруун бүсийн хэмжээнд оношлогоо хийх |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Тээвэрлэлтийн зардлыг шийдэх боломжтой. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс болон хандив тусламжаар |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 2 тэрбум 500 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 2 тэрбум 500 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Баруун бүс нутгийн 315 000 гаруй хүнд оношлогоо хийх боломжтой. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Соронзон давтамжит компьютерийн томограф (MRI)-ийн аппараттай болсноор төвөөс алслагдсан баруун бүс нутгийн иргэдэд цаг хугацаа алдах, эдийн засгийн хэмнэлт гарах, өвчнийг эрт үед нь оношлох улмаар эмчилгээнд ахиц гарч нас баралт буурах сайн талтай |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**190 ОРТОЙ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАРИЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | 190 ортой БОЭТ-ийн барилга |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015-2016 |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Аймгийн төвд 30-аад мянган хүн ам төвлөрөн суурьшдаг байсан бол 2014 онд 40 мянгад хүрч эмчилгээний тасгуудын ачаалал нэмэгдсэн, бүсийн аймгуудаас ирж үйлчлүүлэгчдийн тоо нийт үйлчлүүлэгчдийн 6.3 хувийг эзлэх боллоо. Хүн ам өсөхийн хирээр эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ жил бүр нэмэгдэж байна. Мөн манай аймагт Бельгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр баруун бүсийн оношилгоо эмчилгээний төвийг бэхжүүлэх төслийн хүрээнд 64 зүслэгт компьютерт томографи, дижитал суурин болон зөөврийн рентген, 4D эхо аппарат, тархины доплерт эхо, тархины бичлэгийн аппарат гэх мэт сүүлийн үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэх болсон. БОЭТ-ийн барилга дээрх тоног төхөөрөмжийг оруулж суурилуулах, цахилгааны болон аюулгүй байдлын шаардлага хангахгүй, өрөө тасалгааны хүрэлцээгүй байгаагаас шинээр барилга барих шаардлагатай. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон |
| Хамрах хүрээ | Монгол орны нутаг дэвсгэрийн 27 хувь буюу 415.3 мян км ² нутагтай, нийт хүн амын 15.6 хувь нь оршин суудаг баруун бүсийн ард иргэдийг хамран үйл ажиллагаа явуулна. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн барилгын газар, дэд бүтцийн асуудлууд шийдвэрлэгдсэн ба бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 15 тэрбум |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 15 тэрбум |
| Үйлчилгээний хүчин чадал | Жилд 12000 гаруй хүн хэвтэн эмчлүүлж 120000 гаруй хүнд үзлэг оношлогоо хийдэг. Үүнээс баруун бүсийн бусад аймгуудаас 6,3 хувь хэвтэн эмчлүүлж 8,2 хувь нь үзлэг оношлогоо хийлгэдэг. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Үйлчлүүлэгчид болон хэвтэн эмчилүүлэгчдийн орчин нөхцөл стандартын шаардлага ханган Бельгийн Засгийн газрын төслийн хүрээнд нийлүүлэгдэх орчин үеийн өндөр үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг ашигласнаар эмнэлгийн тусламжийн чанар дээшлэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**20 ОРТОЙ ЭМЧИЛГЭЭ СУВИЛГААНЫ БАРИЛГЫН ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | 20 ортой эмчилгээ сувилгааны барилга |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2016 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Эрүүл мэндийн бодлогын хүрээнд эмчлэн эрүүлжүүлэхээс гадна сувилах, асрах, нөхөн сэргээх үйлчилгээний багц тусламжийг нэвтрүүлэх нь эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй нь батлагдсан болно. Эрүүл мэндийн төвд жилд дунджаар 12000 гаруй хүн хэвтэн эмчлүүлж 120 000 гаруй хүнд үзлэг оношлогоо хийдэг бөгөөд нийт хэвтэн эмчлүүлэгсэдийн 40 хувь нь сувилал, бусад эмийн бус эмчилгээгээр эмчлэгдэх боломжтой нь тогтоогдсон болно. Иргэдийн архагшсан хууч эмгэгийг сувилал, эмийн бус эмчилгээнд хамруулснаар эдийн засгийн үр өгөөж дээшилж иргэндээ ээлтэй үйлчилгээ бий болно. Цаашид энэхүү үйл ажиллагааг өргөжүүлж төр болон хувийн хэвшлийн түншлэлээр сувиллын газар байгуулан иргэдэд үйлчлэх боломжтой |
| Төслийн явц | Төсөл шууд эхлэх бүрэн боломжтой |
| Хамрах хүрээ | сувиллыг баруун бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэн 5 аймгийн иргэдэд үйлчилгээ үзүүлнэ. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг нь төр хувийн хэвшлийн түншлэлээр эрхлэн явуулах боломж олгоно. |
| Санхүүжилтийн хэлбэр | концесс, гадаадын орны хандив, дэмжлэг, хамтарсан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 450 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 450 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Зөвхөн Ховд аймагт жилд 5500 гаруй хүнд эмчилгээ сувилгаа хийх боломжтой бөгөөд бүсийн хэмжээнд үйл ажиллагааг өргөжүүлнэ. . |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Иргэдийн эрэлт хэрэгцээ хангагдаж, эмийн бус үйлчилгээ өргөжин, байгалийн болон зохистой хооллолтын сувиллын төрлүүд нэмэгдэж иргэдэд ээлтэй үйлчилгээ хүргэх боломж дээшлэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**БҮРЭН ТОНОГЛОГДСОН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН МАШИНЫ ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | Бүрэн тоноглогдсон яаралтай тусламжийн авто машин |
| Байршил | Ховд дахь БОЭТ |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Ховд дахь БОЭТ нь Ховд аймгийн 16 сум, харьяа аймгуудын хил заалга сумдуудад алсын дуудлагаар үйлчилгээ үзүүлдэг. Үйлчлэх хүрээний радиусын хамгийн алслагдсан зай 350 км, өвлийн улиралд баруун 3 сумын зам хаагддагаас үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй. Мөн алсын дуудлагын машины 90 хувь нь туулах чадвар муутай, яаралтай тусламжийн тоноглолгүйгээр нийтийн зорчих хөсгөөр тусламж үйлчилгээг үзүүлж байна. |
| Төслийн явц | Нийлүүлэгдэх машины марк үнэ судлагдсан. |
| Хамрах хүрээ | Монгол орны нутаг дэвсгэрийн 27 хувь буюу 415.3 мян км нутагтай, нийт хүн амын 15.6 хувь нь оршин суудаг баруун бүсийн ард иргэдийг хамран үйл ажиллагаа явуулна. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хэмжээнд зайлшгүй шийдвэрлэхээр тусгагдсан |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс болон хандив тусламжаар |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 150,0 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 150,0 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Баруун бүс нутгийн 315000 гаруй хүнд алсын дуудлага болон хот доторхи дуудлагын тусламж үйлчилгээг чанартай, шуурхай үзүүлэх |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Эмнэлгийн яаралтай тусламжийг газар дээр нь үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон зориулалтын машинтай болсноор өвчтөний амь насыг аврах, нас баралтын бууруулах бүрэн боломжтой болох юм. Мөн эмч, өвчтөний амь нас, эрүүл мэндийн эрсдэлгүй байдал бий болно. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМАНД РАШААН СУВИЛАЛЫН ГАЗАР
БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | Чандмань сумын Рашаан, сувилалын газар байгуулах. |
| Байршил | Ховд аймгийн Чандмань сумаас 50 км, Ховд аймгаас 200 км зайд байрлана. |
| Төсөл хэрэгжих хугацаа | 2015 он |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Ховд аймаг болон баруун бүсийн аймгуудад ходоод, мэдрэл, элэг, цөс, үе мөч, шүдний өвчлөл сүүлийн жилүүдэд өсч байгаа бөгөөд эдгээр өвчнүүдийг рашаан сувилалаар эмчлэх нь илүү үр дүнтэй нь батлагдсан. Манай аймагт энэ чиглэлийн рашаан сувилалын газар хараахан байгуулагдаагүй учир Улаанбаатар болон өөр аймагт явж эмчлүүлж, сувилуулж байна. Ховд аймгаас Өвөрхангай аймгийн Хужиртын рашаан сувилал нь 1090 км, хамгийн ойрын рашаан сувилал болох Увс аймгийн Хар-Тэрмэсийн рашаан 290 км-т байдаг нь сувилуулж байгаа ард иргэдэд эдийн засаг болоод цаг хугацааны хувьд хүндрэл учруулж байна. Жилд аймгийн хэмжээнд 70 орчим рашаан сувилалд илгээх бичиг ирж иргэдийг сувилуулж байгаа хэдий ч үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна. Цаашид элс, рашаан түшиглэсэн сувиллыг хөгжүүлэх эрэлт өндөр байна. |
| Төслийн давуу тал | Байгалийн сайханд Их Монгол элс, Бага нуур, Монгол Тахь, 200 нэр төрлийн усны шувуу үзэж, нуураар завиар аялан, сүүн болон шар сүүн бариа хийлгэж, усанд орж наранд, шарах торгон элсээр эмчилгээ хийлгэх боломжтой. Амралт зугаалга болон рашаан сувилалын газрыг нэг дор байгуулах боломжтой. |
| Хамрах хүрээ | Баруун бүсийн аймгуудын ард иргэд.хамрагдах боломжтой |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартаар зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Рашаан сувилал барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 500 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 500 сая |
| Үйлчилгээний хүчин чадал | Нэг дор 150 хүн хүлээн авах хүчин чадалтай, хоол, биеийн тамир чийрэгжүүлэлт, усан болон элсэн эмчилгээ, уламжлалт эмчилгээ зэрэг сүүлийн үеийн шинэлэг технологийг нэвтрүүлсэн үйлчилгээний төрлүүдтэй байна. . |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Рашаан сувилалын газар байгуулснаар рашаан сувилалын үйлчилгээ ард иргэдэд ойртож, орон нутагт чирэгдэл багатай эмчлүүлж сувилуулах таатай нөхцөл бүрдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАРИЛГА

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | 50 ортой Уламжлалт эмнэлгийн барилгыг шинээр барих |
| Байршил | Ховд аймгийн Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015-2016 |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Иргэдэд эмийн бус эмчилгээ үзүүлэхэд орших бөгөөд эрүүл мэндийн салбарын нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэхэд эмийн бус эмчилгээ, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх нь цөм зорилт болж байна. Уламжлалт эмчилгээний төвтэй болсноор өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж, хөрш орнуудтай эмийн бус эмчилгээг өргөжүүлж харилцан туршлагаа солилцох боломж бүрдэж өргөжин хөгжинө. |
| Төслийн явц | Төслийн зорилт нь 4 жилийн хугацаанд хэрэгжих аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан болно. |
| Хамрах хүрээ | Баруун бүсийн аймгууд болох Ховд, Баян-өлгий, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудын ард иргэд.хамрагдах боломжтой |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартаар зохицуулагдана |
| Орон нутгийн дэмжлэг | Уламжлалт эмчилгээний барилга барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлнэ |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. Олон улсын байгууллагын хандив дэмжлэг |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 980 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 980 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Нэг удаадаа 50 хүнийг хүлээн авч иргэдэд эмийн бус эмчилгээ, бариа засал, уламжлалт эм засал, шавар, давс, усан эмчилгээ, гоо засал, хөдөлгөөн, байгалийн онцлогийг хадгалсан төрөлжсөн эрүүл мэндийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүд хамаарагдана |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | А) Эмнэлэг ашиглалтанд орсноор жилд дунджаар хот хөдөөгийн нийт 35 000 гаруй иргэд ашиг шимийг нь хүртэнэ Б) Үйлчилгээний шуурхай байдал дээшилж, иргэдийг чирэгдэлгүй хөнгөн шуурхай, үйлчлэх нөхцөл бүрдэж цаг хугацаа, үйлчилгээний алдагдал буурна. В) Иргэдэд үйлчлэх уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээний тохилог орчин нөхцөл бий болно. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**БОЭТ-ИЙН УГААЛГА, ГРАЖ, МООРГИЙН БАРИЛГА БАРИХ ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|---|
| Төслийн нэр | БОЭТ-ийн угаалга, гражийн барилга |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2016 онд |
| Төслийн зорилго, ажиллагааны чиглэл үйл | БОЭТ-ийн ариутгал, угаалга, мооргийн барилгууд нь 1976 онд ашиглалтанд орсон насжилт өндөр, барилгын хана нурж, мөөгөнцөртөж, дээврээс ус гоожсоноос эдэлгээ муудаж мэргэжлийн хяналтын байгууллагаас үйл ажиллагааг зогсоох дүгнэлт гарсан. Ариутгал хийхэд зориулалтын бус байртай, өрөө тасалгааны хүрэлцээ муу, эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөж буй түгээмэл үйлдлийн стандарт, Эрүүл мэндийн сайдын тушаалын биелэлт ханган ажиллахад хүндрэлтэй, техник аюулгүй ажиллагаа, халдвар хамгаалалын дэглэм зөрчигдсөн учир шинээр барилга барих шаардлагатай. |
| Төслийн явц | Төслийн зорилт нь 4 жилийн хугацаанд хэрэгжих аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан болно. |
| Хамрах хүрээ | Аймгийн хэмжээнд жилд дунджаар 23 мянга орчим хэвтэн эмчлүүлэгсэдийн зөөлөн эдлэлийн угаалга, ариутгал, 350-400 нас барагсадад үйлчлэх цогцос хадгалах байр, 4000 орчим алсын дуудлагаар үйлчлэх яаралтай тусламжийн машины гражийн үйлчилгээний бэлэн байдлыг хангаж болно. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлнэ |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 950 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 950 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Өдөрт дунджаар 350 үйлчлүүлэгсэдийн зөөлөн эдлэлийг угаах, 15 машин хадгалах граж, 10-15 нас барагсадыг нэг ээлжиндээ хүлээн авч үйлчлэх мооргийн барилгатай байна. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Угаалга, гражыг шинээр барьж, тухайн объектын гүйцэтгэдэг ажлыг гэрээгээр гүйцэтгэх боломжтой, жилээс жилд хувийн хэвшлийн эмнэлгүүд нэмэгдэж, үйл ажиллагаа нь тэлж байгаа тул бусад эмнэлгүүдэд угаалга гражийн болон мооргийг занданшуулах, шатаах, тусгайлан хүлээлцүүлэх өрөө тасалгаа зэрэг иж бүрдэл бүхий үйлчилгээний орчин бүрдэх боломжтой. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

75 ОРТОЙ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ ШИНЭЭР БАРИХ

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|
| Төслийн нэр | 75 ортой хүүхдийн эмнэлэг шинээр барих |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015-2016 |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэх |
| Төслийн явц | Зураг төсөв хийгдэж бэлэн болсон |
| Хамрах хүрээ | Аймгийн болон 16 сумдын хүүхдүүдэд үйлчилэх боломжтой |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартаар зохицуулагдана |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар олгох дэд бүтцийг шийдвэрлэх болон бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлнэ |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. Олон улсын байгууллагын хандив дэмжлэг |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 700 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 700 сая |
| Үйлчилгээний хүчин чадал | 75 хүүхдийг эрчимт эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх нөхцлөөр хангасан, нөхөн сэргээх, оношлогооны хэсэг, урьдчилан сэргийлэх хэсэг, сувилахуйн тусламж, удирдлагын болон аж ахуйн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн цогц үйлчилгээг хүргэнэ. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Шинэчлэлийн Засгийн газар болон Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хэмжээнд зайлшгүй шийдвэрлэх зорилтод тусгагдсан, Эрүүл мэндийн салбарт Засгийн газраас дэвшүүлж буй бусад төсөл хөтөлбөртэй уялдаж хөдөөгийн нийт 40 000 гаруй хүүхэд залуучууд ашиг шимийг нь хүртэнэ |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

ШИНЭ СУУРЬШЛИЙН БҮСЭД ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА БАРИХ

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|---|--|
| Төслийн нэр | Шинэ суурьшлийн бүсэд өрхийн эрүүл мэндийн төв барих |
| Байршил | Ховд аймгийн Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2016 |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэхэд төслийн зорилго орших бөгөөд өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг өргөжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. |
| Төслийн явц | Төсөл аймгийн хөгжлийн төлөвлөлт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаа |
| Хамрах хүрээ | Аймгийн төвийн шинэ суурьшлийн бүсийн 15000 иргэд өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдана |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартаар зохицуулагдана |
| Орон нутгийн дэмжлэг | Барилга барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг нь төр хувийн хэвшлийн түншлэлээр эрхлэн явуулах боломж олгоно. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. Олон улсын байгууллагын хандив дэмжлэг |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 550 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 550 сая |
| Үйлчилгээний хүчин чадал | Төсөл хэрэгжүүлснээр хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний орчинд соёлч, шуурхай үйлчилгээ бий болж, өвчнийг эрт үед нь оношилж хүндрэлээс урьдчилан эмчлэх боломж нэмэгдэх бөгөөд хүрээлэн буй орчинд ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй болно |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Уг барилгыг бариснаар жилд дунджаар алслагдсан шинэ суурьшлийн бүсийн хөдөөгийн нийт 15 000 гаруй иргэд ашиг шимийг нь хүртэнэ Б) Барилга ашиглалтанд орсноор үйлчилгээний шуурхай байдал дээшилж, иргэдийг чирэгдэлгүй хөнгөн шуурхай, үйлчлэх нөхцөл бүрдэж цаг хугацаа, үйлчилгээний алдагдал буурна. В) Иргэдэд үйлчлэх тусламж үйлчилгээний тохилог орчин нөхцөл бий болно. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ХОВД АЙМАГТ НАМ МОЛЕКУЛТ ДУСЛЫН ШИНГЭНИЙ
ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСӨЛ**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|--|
| Төслийн нэр | Баруун бүсийн нам молекулт дуслын шингэний үйлдвэр барих |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сумын Ховд хотод |
| Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Завхан, Говь-Алтай, Увс, Баянөлгий, Ховд аймгийн иргэдийн хэвтэн эмчлүүлэгсэдэд хэрэглэж байгаа нам молекулт судсаар сэлбэх шингэнүүдийг Монгол, Солонгосын хамтарсан “АЙВИКО ИНТЕРНЭШНЛ” ХХК хангаж байгаа бөгөөд жилд дунджаар Тендерийн болон тендерийн бус захиалгаар 22 нэр төрлийн судсаар сэлбэх шингэнийг хэрэглэж байгаа нь эмийн төсвийн 20 орчим хувийг эзэлж байна. Улаанбаатар хотоос дуслын шингэн тээвэрлэж, татан авалт хийж хангахад тээвэрлэлтийн зардал өндөр, тээвэрлэх явцад 10%-нь хагарах эрсдэлтэй байдаг зэргээс шалтгаалан бүсийн хэмжээнд үйлдвэр байгуулж үйл ажиллагааг өргөжүүлэх эрэлт хэрэгцээ байна.. |
| Төслийн явц | Төсөл хэрэгжих нөхцөл бүрдсэн |
| Үйлдвэрлэх бүтээгдэхүүн | Хордлого тайлах болон, тариа найруулах нам молекулт дуслын шингэн |
| Зах зээлийн багтаамж | Баруун 5 аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад нам даралтын дуслын шингэнээр үйлчлэх боломжтой |
| Хууль эрх зүйн орчин | Эм, эмнэлгийн хэрэгслэлийн тухай хууль, Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 5524:2014 стандартын шаардлагыг мөрдөх |
| Орон нутгийн дэмжлэг | Эмийн үйлдвэр барих газар олгох, боловсон хүчнээр хангах, бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөх дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв, хандив |
| Төслийн нийт санхүүжилтийн хэлбэр | 900 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 900 сая |
| Үйлдвэрлэлийн хүчин чадал | Баруун бүсийн аймгуудын Эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээнд шаардлагатай нам молекулт дуслын шингэн үйлдвэрлэх, хангах |
| Жилийн борлуулалтын тооцоолол | Жилд дунджаар тендерийн болон тендерийн бус захиалгаар 22 нэр төрлийн судсаар сэлбэх шингэнийг хэрэглэж байгаа нь эмийн төсвийн 20 орчим хувийг эзэлж 3 тэрбум 500 сая төгрөгийн борлуулалт хийгдэж байна. |
| Цэвэр ашгийн тооцоолол | Сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад шингэний хэрэглээ нэмэгдэж байгаа бөгөөд жилдээ нийт тэрбум орчим төгрөгийн дуслын шингэн хэрэглэгдэж байгаа судалгаа байна. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Баруун бүсийн аймгууд ойрхон газраас хэрэгцээтэй шингэнээ хугацаа алдалгүй татан авах боломжтойгоос гадна шингэний тээвэрлэлтийн зардал, үнэ өртөг хэмнэлт гаргах, Эмийн чанар аюулгүй байдал бүрэн хангагдана. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ХОВД АЙМАГТ НЭГ УДААГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗҮҮ, ТАРИУР, ХЭРЭГСЭЛ, ОРООХ,
БООХ МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР**

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|--|--|
| Төслийн нэр | Баруун бүсийн зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн үйлдвэр барих |
| Байршил | Ховд аймгийн Жаргалант сум |
| Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Эмнэлгийн байгууллагуудад хэрэглэгдэж буй зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэлийг ханган нийлүүлэх байгууллагууд импортоор оруулан хангаж байгаа бөгөөд жилд дунджаар 180 гаруй сая төгрөг зарцуулагдаж байна. Улаанбаатар хотоос зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэлийн татан авалт хийж хангахад овор ихтэй учраас тээвэрлэлтийн зардал өндөр, мөн тээвэрлэх явцад зүү тариур хагарч гэмтэх эрсдэлтэй байдаг. Эрүүл мэндийн байгууллагуудын зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэлийн зарцуулалт жил ирэх тусам нэмэгдэж байгаагаас шалтгаалан Баруун бүсийн хэмжээнд “Зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэлийн” үйлдвэр байгуулах шаардлагатай байна. |
| Төслийн явц | Төсөл боловсрогдох шатандаа байна. |
| Үйлдвэрлэх бүтээгдэхүүн | Зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэл үйлдвэрлэх |
| Зах зээлийн багтаамж | Зөвхөн Ховд аймгийн хэмжээнд жилд дунджаар 180 гаруй сая төгрөгийн зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэл зарцуулагдаж байна. |
| Хууль эрх зүйн орчин | Эм, эмнэлгийн хэрэгслэлийн тухай хууль, Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 5524:2014 стандартын шаардлагыг мөрдөх |
| Орон нутгийн дэмжлэг | Эмийн үйлдвэр барих газар олгох, боловсон хүчнээр хангах, бусад шаардлагатай зөвшөөрөл олгох, арга зүйн зөвлөгөө өгөх дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэлбэр | 800 сая |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 800 сая |
| Үйлдвэрлэлийн хүчин чадал | Баруун бүсийн аймгуудын Эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээнд шаардлагатай зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэл үйлдвэрлэх, хангах |
| Жилийн борлуулалтын тооцоолол | Баруун 5 аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад нийт нэг тэрбум орчим Зүү, тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэл хэрэглэгдэж байна. |
| Цэвэр ашгийн тооцоолол | Зөвхөн Ховд аймгийн жилийн дундаж ашгийг тооцож үзэхэд 100 сая төгрөгийн ашигтай байгаа бөгөөд бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахад ашиг 3 дахин нэмэгдэх тооцоололтой |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Баруун бүсийн аймгууд ойрхон газраас хэрэгцээтэй зүү тариур, ороох боох материал, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслэлээ хугацаа алдалгүй татан авах боломжтойгоос гадна тээвэрлэлтийн зардал, үнэ өртөг боломжийн байхаас гадна эм, эмнэлгийн хэрэгслэлийн чанар аюулгүй байдал бүрэн хангагдана. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**“БАРУУН БҮСИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН” БАРИХ
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|---|--|
| Төслийн нэр | Баруун бүсийн “Багшийн хөгжлийн ордон” |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Баруун бүсийн тулгуур төв Ховд аймагт Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд баруун бүсийн багш нар, боловсролын салбарын ажилчид албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, ард иргэдийн насан туршийн хэрэгцээт боловсролыг тасралтгүй хөгжүүлэх мэргэжил арга зүй, удирдлагаар хангах, дэлхийн жишигт нийцсэн сургалт семинар, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулах зориулалтын байртай болж тасралтгүй үйл ажиллагаа явуулах. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Баруун бүсийн аймгууд болох Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудын багш нар болон боловсролын салбарын ажилчид, тухайн чиглэлээр суралцаж байгаа оюутнууд, бусад мэргэжлийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, эцэг эхчүүд, насан туршийн боловсрол эзэмшүүлэх. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Багшийн хөгжлийн ордон барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 8 тэрбум төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 8 тэрбум төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Жилд 8000 багш хамруулж мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлнэ. Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Ховд аймгуудын нийт багш болон боловсролын салбарын ажилтан, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн үндсэн болон бусад сургалтаар дамжуулан тасралтгүй хөгжүүлэх, харилцан холбоотой ажиллах боломж бүрдэх юм. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Баруун бүсийн багш нарын мэргэжил, ур чадвар, заах арга дээшилснээр сурагчдад чанартай боловсрол эзэмшүүлнэ. Багш нар мэдлэг чадвараа дээшлүүлэхээр Улаанбаатар хот явдаг байдал үгүй болж цаг хугацаа, зардал хэмнэх боломжоор хангагдана. Ховд аймагт баруун бүсийн багш нарын туршлага, арга зүй, арга технологийн ололтууд бий болно. Хүүхэд бүр хөгжих орон нутгийн онцлогт уялдсан дэлхийн жишигт нийцсэн боловсролын технологи бий болно. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**“ЦАСТ АЛТАЙ ЦОГЦОЛБОР” СУРГУУЛИЙН 320 ХҮҮХДИЙН
ӨРГӨТГӨЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|--|--|
| Төслийн нэр | “Цаст Алтай цогцолбор” сургуулийн өргөтгөл |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум Цамбагарав багийн нутаг дэвсгэр |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, ажиллагааны чиглэл үйл | Эрүүл, аюулгүй, ая тухтай, тохилог орчинд сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангасан зориулалтын барилга байгууламжтай болох. Байртай болсноор хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, тэдэнд чанартай боловсрол олгох, Ном, Авьяас, Багшийн хөгжил хөтөлбөр, Засгийн Газрын үндэсний хөтөлбөрүүдийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж нөхцөл бүрдэх юм. |
| Төслийн явц | Зураг төсөл , техник эдийн засгийн нөхцөл бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Жаргалант сумын Жаргалан Цамбагарав багийн сургуулийн насны хүүхдүүд болон одоо тус сургуульд сурч, ажиллаж байгаа багш, ажиллагсад, сурагчид. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Өргөтгөл барих өөрийн эзэмшлийн газартай бөгөөд бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход орон нутаг дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 2 тэрбум 800 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 2 тэрбум 800 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | Жилд 1200 сурагчид, 80 гаруй багш, ажиллагсад сурч хүмүүжин, ажиллаж, эцэг олон нийтэд үйлчилгээ үзүүлнэ. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Зориулалтын барилга байгууламжтай болсноор сурагчдад эрүүл аюулгүй орчинд чанартай боловсрол эзэмшүүлж, үндэсний хөтөлбөр Ном, Авьяас, Багшийн хөгжил хөтөлбөр үр дүнтэй хэрэгжинэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ЖАРГАЛАНТ СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙГ БАРИХ
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|---|--|
| Төслийн нэр | Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэг |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум төв талбай |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Цэцэрлэгийн хуучин барилгыг нурааж, 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг барьж ашиглалтанд оруулснаар Жаргалант сумын Жаргалан, Цамбагарав, Наран, Магсаржав багийн 2-5 насны хүүхдийн СӨБ-д хамрагдах эрэлтийг хангах. Одоогийн байдлаар Жаргалан багийн 2-5 насны хүүхдийн дөнгөж 25 хувийг СӨБ-д хамруулж байгаа бол төсөл хэрэгжсэнээр тойргийн хүүхдийн хамралт 40 хүртэлх хувиар нэмэгдэнэ. |
| Төслийн явц | Төсөв болон техникийн холбогдох нөхцөлүүд, тооцоо судалгаа нь хийгдэж, зураг төсөл нь бэлэн болсон ба Аймгийн ИТХ, Боловсролын Яаманд төслийн явц танилцуулагдсан. |
| Хамрах хүрээ | Төр хувийн хэвшил хамтран тус цэцэрлэгийн барилгыг хурдан хугацаанд барьснаар СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа Жаргалан багийн 2-5 насны хүүхдийн хамрагдах хүрээ эрс нэмэгдэж боловсролын цогц үйл ажиллагааг хангагдахад түлхэц болно. |
| Хууль эрх зүйн орчин | Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Ховд аймгийн Засаг даргын 2014 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл бөгөөд, эдийн засгийн хүндрэлийн улмаас 2015 онд цэцэрлэгийн барилгыг барихаар шийдвэрлэсэн санал тооцоо, судалгааг холбогдох яам газруудад дахин хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх явцыг Ховд аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд танилцсан бөгөөд хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэхээр болсон. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг |
| Үйлчилгээний хүчин чадал | СӨБ-н үйлчилгээ үзүүлэх 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 150 хүүхдийн хүчин чадалтай болгосноор багш ажилчидын тоо нэмэгдэж тойргийн хүүхдийн хамрах хүрээ нэмэгдэнэ. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | СӨБ-н хамран сургалтыг нэмэгдүүлэх, Жаргалан багийн СӨБ-д хамрагдах хүүхдийн эрэлт, хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны орон тоо нэмэгдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ЖАРГАЛАНТ СУМЫН 2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ӨРГӨТГӨЛ БАРИХ
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|--|---|
| Төслийн нэр | Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөл. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум Магсаржав баг. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Ховд аймгийн Жаргалант сумын хамран сурган сургалтыг нэмэгдүүлэх, СӨБ-ыг бага насны хүүхдэд ая тухтай, таатай орчинд олгох. |
| Төслийн явц | Санал, Хэлэлцүүлэгийн шатанд байгаа. |
| Хамрах хүрээ | 2-5 насны хүүхдүүд . |
| Хууль эрх зүйн орчин | Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Өргөтгөл барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Олон улсын төсөл хөтөлбөр. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 1 тэрбум 800 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 1 тэрбум 800 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | 6 бүлэг буюу 170 хүүхдийн хүчин чадалтай. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Ховд аймгийн Сургуулийн өмнөх боловсролын хамран сургах сургалт нэмэгдэнэ. Стандарт нийцсэн цэцэрлэгийн орчин бий болно. Мөн шинээр ажлын байр нэмэгдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН 6-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ӨРГӨТГӨЛИЙН
БАРИЛГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|---|---|
| Төслийн нэр | Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэг. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум Буянт баг. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд. |
| Төслийн зорилго, ажиллагааны чиглэл үйл | СӨН-ны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан орчинд хүүхэд сургах, багш ажилчдыг ажиллах таатай нөхцөл боломжоор хангах. Цэцэрлэгийн багтаамж нь 120 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 185 хүүхэд хамрагдаж барилгын хүчин чадал хэтэрсэн тул зайлшгүй өргөтөлийн барилга бариулах шаардлагатай. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Ховд аймгийн Жаргалант сумын Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан, Тахилт багийн СӨН-ы хүүхдүүдийг хамруулах. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 900 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 900 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | 100 хүүхэд хамрагдах байр . |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Бугат багийн нийт хүүхдийг СӨБ-д хамруулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын эрүүл, аюулгүй, ая тухтай орчин бүрдэнэ, ажлын байрны орон тоо нэмэгдэх. СӨБ-д хүүхдүүдийг хамруулсанаар эцэг эхчүүд сэтгэл амар ажиллах нөхцөлөөр хангагдана. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

ЖАРГАЛАНТ СУМЫН 8-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ӨРГӨТГӨЛИЙН**БАРИЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|--|---|
| Төслийн нэр | Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэг. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум Алаг толгой баг. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд. |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | СӨН-ны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан орчинд хүүхэд сургах. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Ховд аймгийн Жаргалант сумын Алагтолгой, Хайрхан,Тахилт багийн СӨН-ы хүүхдүүд. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 900 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 900 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | 100 хүүхэд хамрагдах байр . |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | СӨБ-н хамрагдалт нэмэгдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ЖАРГАЛАНТ СУМЫН 9 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ӨРГӨТГӨЛ БАРИХ ТӨСЛИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|---|--|
| Төслийн нэр | Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэг. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сумын Буянт баг. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд. |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Буянт багт СӨН-ны 380 хүүхдийн судалгаа байдаг боловч манай цэцэрлэгийн багтаамж нь 50 хүүхдийн хүчин чадалтай ,одоогоор 180 хүүхэд хамрагдаж барилгын хүчин чадал хэтэрсэн тул зайлшгүй өргөтөлийн барилга бариулах шаардлагатай. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Буянт багийн хүхдүүд. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Цэцэрлэгийн өргөтгөл барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | 150 хүүхдийн хүчин чадалтай . |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Буянт багийн нийт хүүхдийг СӨБ-д хамруулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын эрүүл, аюулгүй, ая тухтай орчин бүрдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ЖАРГАЛАНТ СУМЫН 10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ӨРГӨТГӨЛ БАРИХ ТӨСЛИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|--|---|
| Төслийн нэр | Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэг. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сумын Тахилт баг. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд. |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Тахилт, Баатархайрхан, Бичигт багуудын СӨН-ны 380 хүүхдийн судалгаа байдаг боловч цэцэрлэгийн барилгын хүчин чадал 75 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай ,одоогоор 3 гэр бүлэг нэмэн ажиллуулж нийт 6 бүлэгт 185 хүүхэд хамрагдаж барилгын хүчин чадал хэтэрсэн тул зайлшгүй өргөтөлийн барилга бариулах шаардлагатай. |
| Төслийн явц | Зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Тахилт, Баатархайрхан, Бичигт багуудын СӨН-н хүүхдүүд. |
| Хууль эрх зүйн орчин | Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Цэцэрлэгийн өргөтгөл барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 1 тэр бум 200 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | 150 хүүхдийн хүчин чадалтай. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Баатархайрхан, Тахилт, Бичигт багуудын бага насны хүүхдүүдийг СӨБ-д хамруулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, багш ажилтаны ажиллах эрүүл, аюулгүй, ая тухтай орчин бүрдэнэ. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**ЖАРГАЛАНТ СУМЫН 13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
БАРИЛГА БАРИХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|--|--|
| Төслийн нэр | Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг. |
| Байршил | Ховд аймаг Жаргалант сум. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2015 онд. |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Аймгийн хэмжээнд 2-5 насны хүүхдийн 61.7 орчим хувь нь цэцэрлэгт хамрагдаж байна. Жаргалант сумын хэмжээнд 12 цэцэрлэгийн 61 бүлэгт нормативаар 1525 хүүхэд хамрагдахаас 2258 хүүхэд хамрагдаж байгаагаас шинээр цэцэрлэг барих зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсч байна. Цэцэрлэгийн насны хүүхдийн сурч хүмүүжих орчинг бий болгох, улмаар эх орондоо зөв монгол иргэнийг бэлтгэх. |
| Төслийн явц | Төсөв болон техникийн холбогдох нөхцөлүүд, тооцоо судалгаа нь хийгдэж, зураг төсөл нь бэлэн болсон. |
| Хамрах хүрээ | Жаргалант сумын иргэд тэдний үр хүүхдүүд, хойч үе. |
| Хууль эрх зүйн орчин | Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай, Концессийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. |
| Орон нутгийн дэмжлэг | Хүүхдийн цэцэрлэг барих газар олгох бусад шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| Санхүүжилтийн хэлбэр | Концесс, улсын төсөв. |
| Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ | 2 тэр бум 800 сая төгрөг. |
| Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ | 2 тэр бум 800 сая төгрөг. |
| Үйлчилгээний хүчин чадал | СӨБ-н үйлчилгээ үзүүлэх 200 хүүхдийн. |
| Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн | Цэцэрлэгийн насны хүүхдийн сурч хүмүүжих таатай орчинг бий болгосноор хүүхэд насаа гэртээ биш цэцэрлэгт сурч хүмүүжиж, улмаар одоо болон хойч үеийнхэнийг эх орондоо зөв монгол иргэн болгон төлөвшүүлэх, эцэг эхчүүд сэтгэл амар ажил амьдралаа зохицуулах. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

**НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА БАРИХ
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл | |
|---|---|
| Төслийн нэр | Нийтийн номын сангийн өргөтгөлийн барилга. |
| Байршил | Шинэ суурьшилын бүс. |
| Төсөл хэрэгжүүлэх хугацаа | 2016 он. |
| Төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл | Ховд аймгийн нийт хүн амд номын сангаар үйлчлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээг ойртуулах, хүн амын төвлөрөл ихтэй газар шинэ салбарыг байгуулах. |
| Төслийн давуу тал | Ном хэвлэл болоод интернэтээр иргэдэд үйлчлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх. |
| Хамрах хүрээ | Хүн амын өсөлт өсөн нэмэгдэж байгаа өнөө үед үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, ойр хүргэх нь үйлчилгээний байгууллагын эрхэм зорилго билээ. Манай Нийтийн номын сан нь одоогийн байдлаар 250 хүнд үйлчлэх хүчин чадалтай боловч ачаалал ихтэй, захын багуудын иргэдэд үйлчлүүлэх боломж нь төдийлөн хангалтгүй байдаг. |
